



131

**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/258

Булган

Г Эрх олгох тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган хотын нийтийн эзэмшлийн зам, талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх цэцэрлэгжүүлэх ажлын 177 000 000 /нэг зуун далан долоон сая/ төгрөгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу захиран зарцуулах эрхийг Булган сумын Засаг дарга /Д.Наранбаяр/-д олгосугай.

2. Эрх шилжсэн ажлын гүйцэтгэлд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Д.Буманбаяр/-т үүрэг болгосугай.

3. Дээрх ажлын санхүүжилтийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ